

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2026.01.05

Улаанбаатар хот

Д/д	Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлууд	Биелэлт	Биелэлтийн хувь
1.	Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт шинжилгээ хийх	Дүүргийн хэмжээнд нэгдүгээр улиралд 50 тогтоол, шийдвэрийн 91 заалт 73 хувьтай хэрэгжих шатанд байсан хагас жилийн байдлаар 34 тогтоол, шийдвэрийн 63 заалт 65 хувь, 3 дугаар улиралд 85 хувь, жилийн эцэст 52 тогтоол, шийдвэрийн 97 заалт 91,4% хэрэгжсэн бөгөөд тухай бүр хяналт шинжилгээ хийн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь илгээн тайлагнасан. Үүнд: Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын 29 шийдвэрийн 55 заалт, Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх	100%
2.	Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх		100%
3.	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс тус дүүргийн хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ хийх	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх Таван жилийн үндсэн чиглэлээс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх 1 бүлэг, 2 зорилт 4 арга хэмжээ жилийн эцсийн байдлаар 96.2%, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2 бүлгийн 3 арга хэмжээ 96.6%, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1 арга хэмжээ эхний жилийн эцсийн байдлаар 100%-үр дүнтэй хэрэгжиж, тайланг нийт 62 хуудас нотлох баримт, хяналт-шинжилгээний илтгэх хуудсын хамт 2025 оны 12 дугаар сарын 01-ний 04/1816 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэнрүү цахимаар илгээж, тайлагнасан.	100%
4.	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс тус дүүргийн хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ хийх	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлээс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх 3 арга хэмжээ жилийн байдлаар 100 %, хяналт-шинжилгээний 3 шалгуур үзүүлэлт 100%, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4 бүлэг, 6 зорилго, 14 зорилт, 23 арга хэмжээ хагас жилийн байдлаар 70%, жилийн эцэст 96%, 3 бүлгийн 17 шалгуур үзүүлэлт 93,8%, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 5 бүлэг, 11 зорилго, 14 зорилтын 23 арга хэмжээ дунджаар 91%, 2 бүлгийн 5 шалгуур үзүүлэлт 100%-үр дүнтэй хэрэгжиж, тайланг 53 хуудас нотлох	100%


Д/д	Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлууд	Биелэлт	Биелэлтийн хувь
		баримт, хяналт-шинжилгээний илтгэх хуудсын хамт 2025 оны 12 дугаар сарын 01-ний 04/1816 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэнд хугацаанд цахимаар илгээж, тайлагнасан.	
5.	Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төлөвлөгөөний биелэлтэд батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ хийх	Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3 бүлэг 15 зорилго, 90 зорилтын хүрээнд 136 арга хэмжээ жилийн эцсийн байдлаар 90,8%, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 94 шалгуур үзүүлэлт 88,2% үр дүнтэй хэрэгжиж, тайлан нэгтгэлийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, 2025 оны 15 тогтоолоор "Хангалттай" үнэлэгдсэн.	100%
6.	Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн тайланд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн тайлангийн 15 зорилго, 61 зорилт, 122 арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 71,2%, "Хангалттай" хэрэгжилттэй байсан бөгөөд жилийн эцэст 93,3% бүрэн хангалттай хэрэгжиж, хяналт шинжилгээ, үнэлгээний илтгэх хуудсын хамт нийслэлийн Засаг даргын Тамгын газарт заасан хугацаанд албан бичгээр болон цахимаар илгээж, тайлагнасан.	100%
7.	Хан-Уул дүүрэгт ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ хийх	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тайланд эхний 6 сард 14 хоног тутам хяналт шинжилгээ хийсэн. Улирал тутмын хяналт шинжилгээгээр зөрчил гомдлыг бууруулах зөвлөмжийг тухай бүр өгч, мэдээ, тайланг удирдлагад танилцуулж ажилласан. Үүний үр дүнд өмнөх онтой харьцуулбал дүүрэгт бүртгэгдсэн өргөдөл 2,7%, гомдол 17%, хугацаа хэтэрсэн шийдвэрлэлт 90,9%, шийдвэрлэх явцын зөрчил 24,8%-иар тус тус буурсан байна.	90%
8.	Дүүргийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны явц, гүйцэтгэлд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Дүүргийн засаг захиргааны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагааны 2025 оны хагас жилийн гүйцэтгэлд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, тайланг удирдлагад танилцуулсан. Жилийн эцсийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэхдээ байгууллагын чиг үүргийн хэрэгжилт, архивын улсын үзлэгийн дүн гэсэн 2 агуулгын хүрээнд 8 үндсэн үзүүлэлтээр дүүргийн төр захиргааны болон орон нутгийн өмчит нийт 30 байгууллага, 25 хорооны үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.	100%
9.	Дүүргийн Засаг даргын Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Засгийн	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч дүүргийн Засаг даргатай байгуулсан 2025 оны Хариуцлагын гэрээний эхний хагас жилд 53,8%,	91,1%

Д/д	Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлууд	Биелэлт	Биелэлтийн хувь
	газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх Хариуцлагын гэрээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	жилийн эцэст 91,1 хувь үр дүнтэй хэрэгжүүлж 149 хуудас тайланг 04/959 дүгээр албан бичгээр, 175 хуудас тайланг 04/1829 дүгээр албан бичгээр тус тус нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт Илтгэх хуудсын хамт илгээж, тайлагнасан.	
10.	Нийслэлийн Засаг даргын шуурхай, үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэх	Нийслэлийн удирдах ажилтнуудын 22 шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн 106 үүрэг даалгаврын биелэлтийг холбогдох хэлтэс албадаас авч нэгтгэн тухай бүр хяналт шинжилгээ хийж, дүгнэлт, тайланг UB ERP системийн Хяналт шинжилгээ үнэлгээний программд заасан хугацаанд байршуулж, тайлагнасан. Нийт 106 үүрэг даалгаврын биелэлтэд хийсэн хяналт шинжилгээний дундаж 89,15 хувь байна.	89,1%
11.	Дүүргийн Засаг даргын шуурхай, үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэх	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 21 удаа зохион байгуулж, 134 үүрэг даалгаврыг холбогдох хэлтэс албадад хүргүүлэн, товлосон хугацаанд биелэлтийг Засаг даргын дэргэдэх 25 хэлтэс албадын 14 хоногийн нөхцөл байдлын мэдээний хамт авч нэгтгэн, хяналт шинжилгээ хийж тухай бүр шуурхай зөвлөгөөнд болон удирдлагуудад танилцуулж ажилласан. Нийт 134 үүрэг даалгавар дунджаар 80 хувь хэрэгжсэн.	80%
12.	Бусад /Цаг үеийн шаардлагаар хийгдэх хяналт шинжилгээ, үнэлгээ/	- Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан байгууллагын SWOT, PESTEL шинжилгээг хийсэн. Мөн нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өгсөн зөвлөмжийн дагуу боловсруулсан байгууллагын 2025-2028 оны стратегийн 8 зорилгод Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг ISO-9001:2015 стандарт нэвтрүүлэх ажлын хэсгээс гарсан саналуудтай уялдуулан тусгаж, холбогдох саналуудыг тухай бүр өгсөн. - Дүүргийн Засаг даргын 2025 оны А/422 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралтын 6 дугаар ажлын хэсгийн гишүүнээр томилогдсон. Батлагдсан хуваарийн дагуу 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 23-ны өдрийг дуустал хугацаанд дүүргийн Өлзийт, Био, Шувуун fabriкийн нутаг дэвсгэрт байрлах 3 хороо, Ерөнхий боловсролын сургууль -5, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага – 6, Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба-2, орон нутгийн өмчит газар-2, нийт 18 байгууллагад “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг”-ийг хуваарийн дагуу зохион байгуулсан. Ажлын хэсгийн нэгтгэсэн дүн, илтгэх хуудсыг 2025 оны 11 дүгээр сарын 05-нд дүүргийн дэд ажлын хэсэгт илгээж, тайлагнасан.	100%

Д/д	Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлууд	Биелэлт	Биелэлтийн хувь
		“ВОРЛД СТАНДАРТ КОНСАЛТИНГ” ХХК-ийн зөвлөх багийн “ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоо” сургалтуудад бүрэн хамрагдаж өгсөн үүрэг даалгавруудыг тухай бүр гүйцэтгэсэн. Төлөвлөсний дагуу сонирхогч талын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, холбогдох дүгнэлтийг гарган Эрсдэлээс сэргийлэх төлөвлөгөө, Эрсдэлийг удирдах журмыг хуваарилагдсан багийн бусад гишүүдийн хамт боловсруулж, удирдлагаар батлуулан урьдчилсан дотоод аудитад шалгуулахад бэлэн болсон.	
13.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, хүргүүлэх	Дүүргийн засаг захиргааны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагааны 2025 оны хагас жилийн гүйцэтгэлд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, тайланг удирдлагад танилцуулсан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмжийг Засаг даргын Тамгын газрын 2025 оны 04/1350 дугаар албан бичгээр дэргэдэх 30 байгууллагад хүргүүлж, биелэлтийг жилийн эцсийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд харгалзан тооцсон.	100%
ДУНДАЖ БИЕЛЭЛТ			96,16%

ТАНИЛЦСАН:
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
 АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
 ГҮЙЦЭТГЭГЧ  З.БУЯАНТ

ХЯНАСАН:
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
 ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
 ГҮЙЦЭТГЭГЧ  Ч.МӨНХГЭРЭЛ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
 БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ
 ХАРИУЦСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
 МЭРГЭЖИЛТЭН  Н.АЛДАРМАА